



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" 9/36 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/48 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/48 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх хот тохижилт, нийтийн аж ахуй, барилгын засвар, шинэчлэлтийн ажлын 76, 77, 81, 94 дүгээр ажил, 3 дугаар хавсралтаар батлагдсан худалдан авах зарим техник, тоног төхөөрөмжийн жагсаалтын 17 дугаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажиллахыг Үнэлгээний хороо /Э.Энхцэцэг/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 08 сарын 24 өдрийн
А.Д.Дундговь тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|----------------------|-------------|--|
| Дарга | Э.Энхцэцэг | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, Санхүүгийн хэлтсийн дарга |
| Гишүүд | Г.Билгүүн | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн |
| | Б.Түмэнбаяр | Нийслэлийн мэдээлэл, технологийн газрын Мэдээллийн сүлжээ, техник, хяналтын хэлтсийн дарга |
| | Д.Батболд | Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороо, Ж31-5166 тоот иргэн /зөвшилцсөнөөр/ |
| Нарийн бичгийн дарга | Э.Хишигбуян | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн |